



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/40

Мандалговь

Эрсдэлт нөхцөлд амьдарч буй өрхүүдэд
"Хүнсний багц" олгох тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгын газрын 201 дүгээр тогтоол "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам"-ын 3.1 дэх хэсэг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн "Хүүхдийн эрхийг хамгаалах урьдчилан сэргийлэх тухай" 01 дүгээр албан даалгавар, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн улс орнуудад шинэ төрлийн корона вирус дэгдсэнтэй холбогдуулан халдвар авах эрсдлээс урьдчилан сэргийлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа гэр бүлүүдэд "Хүнсний багц" олгох ажлыг 2020 оны 06 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Эрсдэлт нөхцөлд амьдарч буй өрхүүдэд "Хүнсний багц" олгох ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар тус тус баталсугай.
3. Үйл ажиллагаанд шаардагдах 3.718.800 (Гурван сая долоон зуун арван найман мянга найман зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам), гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ

481190073

Дундговь аймгийн гэр бүл, хүүхэд
залуучуудын хөгжлийн газрын 2020
оны ᠘ дугаар сарын ᠗-ны өдрийн
А/Х тоот тушаалын ᠗ дүгээр хавсралт

᠑᠑115
᠑5252

ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД АМЬДАРЧ БУЙ ӨРХҮҮДЭД
“ХҮНСНИЙ БАГЦ” ОЛГОХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Бүжинлхам

Гишүүд:

Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч

Б.Мөнх-Оргил

Архив бичиг хэрэг, олон нийт хариуцсан
ажилтан

Э.Мөнхдалай

Нярав

-----oOo-----

Дундговь аймгийн гэр бүл, хүүхэд
залуучуудын хөгжлийн газрын 2020
оны ᠙ дугаар сарын ᠒᠑-ны өдрийн
᠒᠙᠙᠓ тоот тушаалын ᠒᠑ дугаар хавсралт

ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД АМЬДАРЧ БУЙ ӨРХӨД
"ХҮНСНИЙ БАГЦ" ОЛГОХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэг өрхөд оногдох багцад хамаарах зүйлс	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Нэг өрхөд оногдох багц					
Ариун цэврийн хэрэгсэл					
1	Гарын саван /шингэн/	ш	1	5500	5500
2	Санитол	ш	1	6000	6000
Хүнсний бүтээгдэхүүн					
3	Гурил	кг	10	14000	14000
4	Будаа	кг	5	15000	15000
5	Ургамлын тос	л	1	4000	4000
6	Гоймон	кг	3	8200	8200
Нэг өрхөд оногдох багцийн нийт дүн:					52.700
Нийт					
7	Шатахуун	л	20	1490	29.800
8	Хүнсний багц	багц	70	52700	3.689.000
Нийт					3.718.800

-----oOo-----